

Төсөл 2016.10.20

ТАНИЛЦУУЛГА

“Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийн талаар

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын тус улсад зорчих нөхцлийг хөнгөвчлөх, эрх зүйн зарим зохицуулалтыг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах зорилгоор холбогдох өөрчлөлтүүд оруулах саналаа танилцуулж байна.

Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-аар тус улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэх, бүртгэлээс хасах, оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хугацаа сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг зохицуулж байна.

Гадаадын иргэн Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгахад төрийн зарим байгууллагаас зөвшөөрөл авахыг шаарддаг бөгөөд энэхүү төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, түргэн шуурхай, чирэгдэлгүй нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, гадаадын иргэдээс шаардах баримт бичгийг багасгах үүднээс дараахь өөрчлөлтүүдийг оруулах саналтай байна:

1. Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу авсан гадаадын иргэн 183 хоногийн дараа оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжтой байсныг 90 хоногийн дараа дахин тухайн зөвшөөрөл хүссэн оршин суух хэлбэрээр тус улсад хувийн хэргээр оршин суух хүсэлт гаргаж болохоор тусгалаа;

2. Хөрөнгө оруулагч гадаадын иргэнийг хөрөнгө оруулалтын хэлбэр, хэмжээнээс үл шалтгаалан 3 хүртэл жилийн хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг сунгаж байсныг өөрчлөн Монгол Улсад хөрөнгө оруулсан хэлбэрээр оршин суух зөвшөөрлийг ялгамжтай олгож, үйл ажиллагааны тогтворжилт, татвар төлөлт, Монгол Улсын иргэнийг ажлын байраар хангасан байдал зэргийг харгалзан оршин суух зөвшөөрлийн хугацааг 1 хүртэл жилээр олгож, 3 хүртэл жилээр сунгаж байхаар зохицуулсан.

Түүнчлэн хөрөнгө оруулагч гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, сунгахад шаардах баримт бичгийг багасгах, давхардлыг арилгах зорилгоор төрийн байгууллагуудын (татвар, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага) хоорондын мэдээллийн санд үндэслэхээр журамд зааж өгсөн;

3. Монгол Улсад дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар ирж буй гадаадын

иргэнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгосон тодорхойлолтыг үндэслэн оршин суух зөвшөөрөл олгодог байсныг хөнгөвчлөн тус яамнаас зөвшөөрөл авахыг шаардахгүйгээр дээд болон мэргэжлийн боловсролын байгууллага нь шууд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандан оршин суух зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Ингэснээр Монгол Улсад дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэн төрийн үйлчилгээг нэг цэгээс авах боломж бүрдсэн;

4.Гадаадын иргэдэд оршин суух зөвшөөрөл олгоход хязгаарлалт болдог зарим зохицуулалтыг хассан. Тухайлбал, Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх зорилгоор ирсэн гадаадын иргэн тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авснаас хойш 6 сарын дараа гэр бүлийн гишүүндээ хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргадаг байсныг өөрчилж Монгол Улсад гэр бүлийн гишүүний хамт орж ирэн оршин суух зөвшөөрөл авах боломжийг бүрдүүлсэн.

5.Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний эхнэр, нөхөр, эцэг, эхэд олгох оршин суух үнэмлэхийг тусгайлан зааж, хувийн хэрэг хөтлөж, оршин суух зөвшөөрөл хүсэхэд нь гадаадын иргэний гурван үеийн намтар зэргийг бүрдүүлэхийг шаардан холбогдох хууль хяналтын байгууллагаас санал авч байхаар тусгалаа.

6. Монгол Улсад зорчигч гадаадын иргэний (16 насанд хүрээгүй болон дипломат паспорттай, дипломат дархан эрх ямба эдэлж буй гадаадын иргэнээс бусад) хүний биеийн давхцахгүй өгөгдөл /биометрик өгөгдөхүүн/-ийг хилийн боомтод нэг удаа авахаар журамд зааж өгсөн. Ингэснээр гадаадын иргэн аюул осолд өртсөн тохиолдолд таньж олох,гадаадын иргэнийг учирч болох эрсдлээс хамгаалах иргэний эрх зүйн хамгаалалт болох, нөгөө талаар бусдын баримт бичгийг ашиглан улсын хилийг хууль бусаар нэвтрэх, гэмт хэрэг зөрчилд холбогдсон тохиолдолд гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ.

7. Мөн гадаадын иргэний паспортын хүчинтэй хугацаа оршин суух зөвшөөрөл олгоход 1 жил, сунгахад 6 сараас доошгүй хугацаатай байх бөгөөд гэмтэлгүй байхыг шаарддаг байсныг хассан.

8. Гадаадын иргэнд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор гадаадын иргэнийг бүртгэхдээ албан бичиг, өргөдөл, паспортын хуулбар шаарддаг байсныг хассан.

9. Гадаадын иргэн, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суух зөвшөөрөл олгох, сунгуулах хүсэлтээ цахимаар мэдүүлэх эрх зүйн зохицуулалтыг журамд нэмж тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оныдугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 340 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ж.ЭРДЭНЭБАТ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ БОЛОН ТҮҮНИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "гадаадын иргэн" гэх/-ийг бүртгэх, бүртгэлээс хасах, оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.2.Иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд энэ журмыг мөрдөхгүй.

Хоёр. Гадаадын иргэнийг бүртгэх

2.1.Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суух болон төрийн байгууллагын урилгаар ирсэн, Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т заасан байгууллагад ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор урьж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, буцах үед бүртгэлээс хасуулна.

2.2.Энэ журмын 2.1-д зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.

2.3.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.1-д заасан хувийн хэргээр оршин суугч нь оршин суух зөвшөөрлийн хугацаанд дахин бүртгүүлэхгүй.

2.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг бүртгэхдээ тухайн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг (цаашид "паспорт" гэх), 3.5х4.5 см хэмжээний гэрэл зургийг зохих мэдүүлгийн хуудасны хамт хүлээн авч бүртгэнэ.

2.5.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэний паспортад бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он, сар, өдөр бүхий "бүртгэв" гэсэн дардас дарж, тухайн гадаадын иргэний болон уригчийн талаарх мэдээллийг мэдээллийн санд оруулан мэдүүлгийн хуудсанд тэмдэглэл хийнэ.

2.6.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хилийн боомт болон орон нутаг дахь алба нь хил орчмын нутагт зорчих үнэмлэхээр ирсэн гадаадын иргэн зорчих үнэмлэхэд заасан хилийн боомтоор нэвтэрч, зөвшөөрсөн хил орчмын нутагт зорчиж, хугацаандаа гарч байгаа эсэхийг бүртгэж, хяналт тавина.

2.7.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хилийн боомтод дор дурдсанаас бусад гадаадын иргэнээс нэг удаа хүний биеийн давхцахгүй өгөгдлийг авна:

2.7.1.16 насанд хүрээгүй;

2.7.2.дипломат паспорттай, дипломат дархан эрх ямба эдэлж буй гадаадын иргэн.

Гурав. Албан хэргээр Монгол Улсад оршин суух

3.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д заасны дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага албан хэргээр оршин суух гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг сунгана.

3.2.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасан албан хэргээр оршин суух гадаадын иргэн /A2/, түүний гэр бүлийн гишүүн /F-A2/ оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

3.3.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага албан хэргээр оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

3.4.Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахаас чөлөөлөгдсөн гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг байгууллагын хүсэлтийг үндэслэн 3 хүртэл жилээр олгож, 3 хүртэл жилээр сунгана.

3.5.Албан хэргээр оршин суух гадаадын иргэн зохих мэдүүлгийн хуудас бөглөхөөс гадна дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.5.1.энэ журмын 7.1-д заасан зорилгоор оршин суух бол хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллагын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл;

3.5.2.уригч байгууллагын оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг;

3.5.3.оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн);

3.5.4.3.5x4.5 см хэмжээний 1 хувь гэрэл зураг;

3.5.5.гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох хууль ёсны бичиг баримтын эх хувийг хуулбар болон баталгаат орчуулгын хамт.

Дөрөв. Хувийн хэргээр Монгол Улсад оршин суух

4.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.2-т заасны дагуу хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөн хуулийн 27.4-т заасан гадаадын иргэдийн тоонд багтаан оршин суух зөвшөөрөл олгоно.

4.2.Монгол Улсад хувийн хэргээр орших суух зөвшөөрлийг дараахь хэлбэрээр олгоно:

4.2.1.гэр бүлийн шалтгаанаар

4.2.1.1.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэн /GB1/;

4.2.1.2.Монгол Улсын иргэнээс төрсөн 16/18??? хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд /GB2/;

4.2.1.3.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн болон хувийн бусад зорилгоор оршин суух гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-GB1,Н/;

4.2.1.4.Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх/F-TS/;

4.2.1.5.энэ журмын 4.2.4.1, 4.2.4.2-т заасан гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-T1,T2/;

4.2.1.6.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын төлөөлөгчийн эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-T3/;

4.2.1.7.аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэх хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-HG/;

4.2.1.8.шашны байгууллагад ажиллах гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-SH/;

4.2.1.9.төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагад ажиллах гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-O/;

4.2.1.10.дээд боловсролын байгуулагад суралцах магистр болон түүнээс дээш зэрэг горилогч гадаадын иргэний эхнэр/нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд /F-S1/.

4.2.2.цагаачлан оршин суух /TS/;

4.2.3.хөдөлмөр эрхлэх

4.2.3.1.аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэх /HG/;

4.2.3.2.шашны байгууллагад ажиллах гадаадын иргэн /SH/;

4.2.3.3.төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагад ажиллах гадаадын иргэн /O/.

4.2.4. хөрөнгө оруулах

4.2.4.1.концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах болон санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хөрөнгө оруулалтын хэлбэрээр хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч, удирдах албан тушаалтан /T1/;

4.2.4.2.энэ журмын 4.2.4.1-д зааснаас бусад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч, удирдах албан тушаалтан /T2/;

4.2.4.3.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын төлөөлөгч /ТЗ/;

4.2.5.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх

4.2.5.1.ерөнхий болон дээд боловсролын байгууллагад суралцах гадаадын иргэн /S1/;

4.2.5.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцах гадаадын иргэн /S2/;

4.2.6.хувийн бусад зорилгоор оршин суух

4.2.6.1.Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэн /H1/;

4.2.6.2.Монгол Улсын иргэнээс төрсөн 16/18???-гаас дээш насны гадаадын иргэн /H2/;

4.2.6.3.Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан, гаргах боломжтой гадаадын иргэн /H3/;

4.2.6.4.хууль хяналтын байгууллага /**шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага**/-аас холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл Монгол Улсад зайлшгүй байх шаардлагатай гэж үзсэн гадаадын иргэн /H4/;

4.2.6.5.бусад хувийн зорилгоор оршин суух гадаадын иргэн /H5/;

4.3.Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрөл авах, сунгуулахдаа мэдүүлгийн хуудас бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

4.3.1.тухайн гадаадын иргэнийг уригч байгууллагын оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг (хувь хүн бол өргөдөл);

4.3.2.оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн);

4.3.3.3.5x4.5 см хэмжээний гэрэл зураг 1 ширхэг;

4.3.4.гэр бүлийн гишүүдийн хамт ирэх тохиолдолд гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээ буюу түүнийг орлох баримт бичгийн эх хувийг хуулбар болон баталгаат орчуулгын хамт./сунгуулах тохиолдолд шаардахгүй/

4.4.Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрлийн хэлбэрээс хамааран энэ журмын 4.3-т зааснаас гадна шаардагдах нэмэлт материалыг бүрдүүлнэ.

4.5.Оршин суух зөвшөөрөл хүсэгч нь мэдүүлгийн хуудас, бичиг баримтыг бүрэн гүйцэт, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө.

4.6.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл гадаадын иргэнтэй ярилцлага хийж оршин суух зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

4.7.Энэ журмын 4.2.1.1, 4.2.1.2, 4.2.2, 4.2.6.3-т заасан нэг жилээс дээш хугацаагаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага регистрийн дугаар олгож, энэ журмын 4.2.1.1, 4.2.1.4, 4.2.2, 4.2.6.3-т заасан гадаадын иргэнд хувийн хэрэг хөтлөнө.

4.8.Энэ журмын 4.2.1.1, 4.2.2-т заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ оршин суух зөвшөөрлийн хугацаа

дуусахаас 30 хоногийн өмнө, бусад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн ажлын 5 хоногийн өмнө гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

4.9.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу авсан гадаадын иргэн 90 хоногийн дараа дахин тухайн зөвшөөрөл хүссэн оршин суух хэлбэрээр тус улсад хувийн хэргээр оршин суух хүсэлт гаргаж болно.

4.10.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл хүссэн бичиг баримтыг эх хувиар нь шаардаж болно.

Тав. Гэр бүлийн шалтгаанаар Монгол Улсад оршин суух

5.1.Энэ журмын 4.2.1.1, **4.2.1.4**-т заасан гадаадын иргэн нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл авахдаа мөн журмын 4.3-т зааснаас гадна дараахь нэмэлт бичиг баримтыг бүрдүүлнэ:

5.1.1.Монгол Улсын болон гадаадын иргэний гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эхийн);

5.1.2.гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

5.1.3.дархлалын олдмол хомсдолын өвчний шинжилгээний бичиг;

5.1.4.амьжиргааны эх үүсвэрийн талаарх өөрийн гаргасан нотолгоо.

5.2.Монгол Улсын иргэнээс төрсөн 16/18 ?? хүртэл насны гадаад улсын харьяат хүүхэд гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл авахдаа энэ журмын 4.3-т зааснаас гадна эцэг эх, асран хамгаалагчийн бичиг баримтын эх хувийг хуулбарын хамт бүрдүүлсэн байна.

5.3.Энэ журмын 4.2.1.1, 4.2.1.3, **4.2.1.4**-т заасан гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль хяналтын байгууллагаас санал авсны үндсэн дээр олгоно.

5.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэр бүлийн шалтгаанаар оршин суух гадаадын иргэнд дор дурдсан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хугацааг олгож, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ:

5.4.1.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийг эхний 2 жилд 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгах бөгөөд цаашид удаан хугацаагаар амьдрах бол 3 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

5.4.2.Монгол Улсын иргэнээс төрсөн 16/18? хүртэл насны гадаад улсын харьяат хүүхдэд оршин суух зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгож, 3 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

5.4.3.энэ журмын 4.2.1.1, **4.2.2**, 4.2.3, 4.2.4, 4.2.5.1, 4.2.6-д заасан гадаадын иргэний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаагаар түүний гэр бүлийн гишүүний тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа тодорхойлогдоно.

5.5.Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэний хүүхэд нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

5.6.Хөгжлийн бэрхшээлтэй гадаадын иргэн хүүхдийг насанд хүрсэн гэх үндэслэлээр оршин суух хэлбэрийг өөрчлөхийг шаардахгүй.

Зургаа. Монгол Улсад цагаачлах

6.1.Монгол Улсад цагаачлах зөвшөөрлийг тухайн гадаадын иргэний цагаачлах тухай хүсэлт, боловсрол, мэргэжил, улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж болон холбогдох хууль хяналтын байгууллагын саналыг харгалзан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29.5-д заасан тоонд багтаан эхний 2 жилд 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана. Цаашид удаан хугацаагаар амьдрах бол 2 хүртэл жилийн хугацаагаар тухай бүр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгана.

6.2.Монгол Улсад цагаачлан амьдрах хүсэлт гаргагч гадаадын иргэн нь дараахь **ерөнхий** шалгуурыг хангасан байна:

6.2.1.сарын орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлснээс багагүй байх;

6.2.2.дээд боловсрол буюу Монгол Улсад онц чухал шаардлагатай мэргэжил эзэмшсэн байх;

6.2.3.гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй байх;

6.2.4.Монгол Улсаас албадан гаргаж, тус улсад орох эрхийг нь хязгаарлаж байгаагүй байх.

6.3.Монгол Улсад цагаачлан амьдрах хүсэлт гаргагч гадаадын иргэн нь энэ журмын 4.3-т заасан бичиг баримтаас гадна дараахь нэмэлт материалыг бүрдүүлнэ:

6.3.1.гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг эх, эмэг эх, өвөг эцгийн);

6.3.2.гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

6.3.3.дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэгийн өвчний шинжилгээний бичиг болон сэтгэцийн өвчтэй эсэх тухай эмнэлгийн байгууллагын магадалгаа;

6.3.4.амьжиргааны эх үүсвэрийн талаарх баталгаа;

6.3.5.3.5x4.5 см хэмжээний 3 хувь гэрэл зураг;

6.3.6.боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын эх хувийг хуулбар болон **баталгаат** орчуулгын хамт.

6.4.Цагаач гадаадын иргэнээс Монгол Улсад төрсөн хүүхдэд 1 сарын дотор оршин суух зөвшөөрөл авах хүсэлтийг гаргана.

6.5.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагаач гадаадын иргэнээс төрсөн хүүхдэд регистрийн дугаар олгож хувийн хэрэг хөтөлнө. Регистрийн дугаарыг төрсний гэрчилгээнд бичнэ.

6.6.16 насанд хүрээгүй цагаач иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа эцэг эх, асран хамгаалагчийн оршин суух зөвшөөрлийн хугацаагаар тодорхойлогдоно.

6.7.Монгол Улсад төрсөн цагаач гадаадын иргэний цагаачлах зөвшөөрлийг 3 хүртэл жилийн хугацаагаар тухай бүр сунгаж болно.

6.8.Цагаач гадаадын иргэнээс төрсөн хүүхдэд оршин суух зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргагч нь гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагаас олгосон мэдүүлгийн хуудас бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.8.1.өргөдөл;

6.8.2.хүүхдийн төрсний гэрчилгээ;

6.8.3.эцэг, эхийн оршин суух үнэмлэх;

6.8.4.хаяг, ам бүлийн талаарх сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;

6.8.5.3.5x4.5 см хэмжээний 3 ширхэг гэрэл зураг.

6.9.Цагаач гадаадын иргэн нь жилд 180 хоногоос хэтрэхгүй хугацаагаар гадаад улсад зорчих бөгөөд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр хяналт тавина.

Долоо. Хөдөлмөр эрхлэхээр Монгол Улсад оршин суух

7.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.3-т заасан бичиг баримт болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон түүний эрх олгосон байгууллагын хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн албан бичгийг үндэслэн гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэхээр оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

Найм. Хөрөнгө оруулагчаар Монгол Улсад оршин суух

8.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадын хөрөнгө оруулагчид дор дурдсан хугацаагаар зөвшөөрлийн хугацааг олгож, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ:

8.1.1.энэ журмын 4.2.4.1-д заасан хөрөнгө оруулагч, удирдах албан тушаалтанд оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, 3 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

8.1.2.энэ журмын 4.2.4.2-д заасан хөрөнгө оруулагч, удирдах албан тушаалтанд хөрөнгө оруулалтын хэмжээ, Монгол Улсын иргэнийг байнгын ажлын байраар хангасан байдал, татвар төлөлт, үйл ажиллагааны тогтворжилтийг харгалзан оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, 2 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

8.1.3.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын төлөөлөгчид оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

8.2.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулагч гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг олгох, сунгахдаа энэ журмын 4.3-т заасан бичиг баримт болон татвар, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт эсхүл мэдээллийн санг үндэслэнэ.

Ес. Суралцах зорилгоор Монгол Улсад оршин суух

9.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил

хийх 16 насанд хүрсэн гадаадын иргэнд дор дурдсан хугацаагаар зөвшөөрлийн хугацааг олгож, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ:

9.1.1.ерөнхий болон дээд боловсролын байгууллагад суралцах гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

9.1.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцах гадаадын иргэнд 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, нэг удаа 1 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

9.2. Энэ журмын 9.1.1, 9.1.2-т заасан гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг сунгахдаа гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн гадаадын иргэний суралцаж байгаа эсэхийг харгалзана.

Арав. Хувийн бусад зорилгоор Монгол Улсад оршин суух

10.1.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хувийн бусад зорилгоор оршин суух гадаадын иргэнд дор дурдсан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгож, сунгах эсэхийг шийдвэрлэнэ:

10.1.1.энэ журмын 4.2.6.1-4.2.6.3-т заасан гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгож, 3 хүртэл жилийн хугацаагаар сунгана.

10.1.2.энэ журмын 4.2.6.4, 4.2.6.5-т заасан гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийг 1 хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.

10.2.Хувийн бусад зорилгоор оршин суух гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгохдоо хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын албан бичгийг үндэслэнэ.

10.3.Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан, гаргах боломжтой гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл хүсэхдээ дараахь нэмэлт материалыг бүрдүүлнэ:

10.3.1.гурван үеийн намтар (өөрийн, эхнэр/нөхөр, эцэг эх, өвөг эцэг, эмэг эхийн);

10.3.2.гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт.

10.4.Бусад хувийн зорилгоор оршин суух гадаадын иргэн /Н5/ оршин суух зөвшөөрөл хүсэхдээ энэ журмын 4.3-т заасан бичиг баримтаас гадна гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг бүрдүүлнэ.

Арваннэг. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааны төрөл, хэлбэр, тэдгээрийг мэдүүлэх

11.1.Гадаадын иргэнийг урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэн өөрөө Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг (цаашид "баталгаа" гэх) виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга, оршин суух зөвшөөрөл авах үед бичгээр гаргана.

11.2.Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэнээс гаргаж байгаа баталгаанд холбогдох эд хөрөнгө нь банк болон бусад аж ахуйн нэгжид барьцаалагдаагүй байна.

11.3.Баталгааг дараахь хэлбэрээр гаргана:

11.3.1.уригч нь тухайн гадаадын иргэнийг оршин суух зөвшөөрлийн болон визийн хугацаанд нь буцаахыг баталсан өргөдөл, албан бичиг;

11.3.2.мөнгөн хэлбэр (дансны хуулга, банкны хадгаламжийн дэвтэр, цалингийн тодорхойлолт, тэтгэврийн дэвтэр гэх мэт).

11.4.Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл гадаадын иргэн энэ журмын 11.3.2-т заасны дагуу баталгаа гаргах бол бичиг баримтын эх хувийг хуулбарын хамт авчирна.

11.5.Энэ журмын 11.3.2-т заасан баталгааны хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байх бөгөөд энэ нь нэг гадаадын иргэнд хамаарна.

Арванхоёр. Оршин суух зөвшөөрлийг хянан шийдвэрлэх ажиллагаа

12.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 31.1-д заасны дагуу гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь оршин суух зөвшөөрөл олгох болон зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг дор дурдсан хугацаанд хянан шийдвэрлэнэ:

12.1.1.энэ журмын 4.2.1.1, 4.2.1.3, 4.2.1.4, 4.2.2, 4.2.6-т заасан гадаадын иргэний Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг 60 хоногийн дотор, уг зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг 30 хоногийн дотор;

12.1.2.Монгол Улсын иргэнээс төрсөн 16 хүртэл насны гадаад улсын харьяат хүүхдэд оршин суух зөвшөөрөл олгох болон сунгуулах хүсэлтийг 30 хоногийн дотор;

12.1.3.энэ журмын 12.1.1, 12.1.2-т зааснаас бусад гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох болон оршин сунгуулах хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор.

12.2.Гадаадын иргэнд хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ тухай хүсэлт гаргагчид шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэж, 10 хоногийн дотор тус улсаас гарахыг сануулан, оршин суух үнэмлэхийг хураан авч, хүчингүй болгоно.

12.3.Оршин суух зөвшөөрөл олгох, сунгуулахыг хүссэн гадаадын иргэнд дараах зүйлийг хориглоно:

12.3.1.худал мэдүүлэг өгөх;

12.3.2.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн биеэр ирэхгүй байх;

12.3.3.оршин суух зөвшөөрөл авсан хэлбэрээрээ өөр аж ахуйн нэгж байгууллагад шилжин ажиллах, суралцах.

12.4.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь түр ирэгчийн Монгол Улсад байх хугацаа дуусмагц түүнийг түр ирэгчийн бүртгэлээс хасна.

12.5. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн тус улсаас бүрмөсөн гарах, оршин суух зөвшөөрлийн хугацаанд буцаж ирэхгүй тохиолдолд гэр бүлийн гишүүний хамт гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оршин суух үнэмлэхээ хураалган, оршин суух бүртгэлээс хасалт хийлгэнэ.

12.6. Түр ирэгчийн болон оршин суух бүртгэлээс хасалт хийхдээ гадаадын иргэний паспортад "хасав" дардас дарж Монгол Улсаас гарах сүүлийн хугацааг зааж өгнө. Гадаадын иргэн нь уг хугацаанд багтаж улсын хилээр гарна.

12.7. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь уригч байгууллагын албан бичгийг үндэслэн түр ирэгчийн болон оршин суух бүртгэлээс хасалт хийнэ.

12.8. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусах өдрөөс хойш хуанлийн 10 хоногоос илүүгүй хугацаагаар бүртгэлээс хасна.

12.9. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлснээс хойш түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх үйлчилгээг ажлын 8 цагт, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгох үйлчилгээг ажлын таван өдөрт, яаралтай үйлчилгээг ажлын гурван өдөрт багтаан гүйцэтгэнэ.

12.10. Албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн дугаарыг тухайн гадаадын иргэний визэнд бичиж тэмдэглэнэ.

12.11. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн оршин суух хэлбэрээ өөрчлөх хүсэлт гаргасан бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянан үзэж оршин суух хэлбэрийг өөрчилж болно.

12.12. Гадаадын иргэн, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суух зөвшөөрөл олгох, сунгуулах хүсэлтээ цахимаар мэдүүлж болно.

~~“Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-аас хасагдсан заалт:~~

~~1. 1.1. Монгол Улсад 30 хөнгөөс дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "гадаадын иргэн" гэх/-ийг бүртгэх, бүртгэлээс хасах, оршин суух зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.~~

~~2. 2.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг бүртгэхдээ уригч иргэний өргөдөл, аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг /уригчгүй гадаадын иргэн өөрөө бүртгүүлэх бол өргөдөл/, тухайн гадаадын иргэний паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиг (цаашид "паспорт" гэх), түүний хуулбар, 3x4 см хэмжээний гэрэл зургийг зохих мэдүүлгийн хуудасны хамт хүлээн авч бүртгэнэ.~~

~~3. 3.4.5.-паспорт, түүний хуулбар;~~

~~4. 4.2. Хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас өлгөсөн мэдүүлгийн хуудсыг бөглөн, дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ:~~

~~5. 4.7. Энэ журмын 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авах болон зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ болон байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувийг хуулбарын хамт тухай бүр авчирна.~~

~~6. 4.11. Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг дараахь хугацаагаар өлгөнө.~~

~~4.11.1. гадаадын иргэн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулах бол уг тусгай зөвшөөрлийн хугацаанаас илүүгүй;~~

~~4.11.2. энэ журмын 7.1, 8.1, 9.1-д заасан гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол тухайн уригч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаанаас илүүгүй~~

~~7. 5.3. Энэ журмын 5.1.1, 5.1.3-т заасан гадаадын иргэн нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа өргөдөл болон оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолт (хаягийн), гэрлэлтийн гэрчилгээг бүрдүүлсэн байна./~~

~~8. 5.11. Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх зорилгоор ирсэн гадаадын иргэн тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авснаас хойш 6 сарын дараа гэр бүлийн гишүүндээ хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах эрхтэй.~~

~~9.-6.9. Цагаач гадаадын иргэн нь жилд 180 хоногоос хэтрэхгүй хугацаагаар гадаад улсад зорчих бөгөөд түүний гадаад улсад зорчсон тухай тэмдэглэлийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр хөтлөн, хяналт тавина~~

~~10. 7.2. Энэ журмын 5.1.1, 6.1-д заасан гадаадын иргэн нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөр эрхэлнэ.~~

~~11.8.2. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 8.1-д заасан зөвшөөрлийг олгоно. Зөвшөөрлийн хугацааг сунгахдаа тухайн гадаадын иргэний татвар төлсөн байдал, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянаж үзэн шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа явуулах албаны байр, хөрөнгө оруулалт нь тус улсад бодитойгоор орсон эсэхийг шалгаж шийдвэрлэнэ.~~

~~12. 8.3. Хөрөнгө оруулагч нь тодорхой үйл ажиллагаа явуулдаггүй, татвар төлөхөөс зайлсхийсэн бол оршин суух зөвшөөрлийн хугацааг богиносгох буюу хүчингүй болгоно.~~

~~13. 12.4. Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах, эсхүл хүчингүй болгоно:~~

~~12.4.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.3, 28.4.1-д заасан үндэслэл байвал;~~

~~12.4.2. худал мэдүүлэг өгсөн~~

~~12.4.3. тухайн гадаадын иргэнийг уригч байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;~~

~~12.4.4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр өөрийн биеэр ирээгүй.~~

~~13. 13.1. Гадаадын иргэний паспортын хүчинтэй хугацаа оршин суух зөвшөөрөл олгоход нэг жил, сунгахад 6 сараас доошгүй хугацаатай байх бөгөөд паспорт гэмтэлгүй байна.~~

~~14.13.2. Монгол Улсад оршин суух хүсэлт гаргагч нь хөлбөгдөх бичиг баримтыг монгол хэл дээр бүрдүүлнэ. Гадаад хэлээр үйлдсэн бичиг баримтыг монгол хэлээр орчуулсан байна.~~

~~15. 13.3. Албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө Монгол Улсад орж ирсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах боломжгүй болсон тохиолдолд энэ журмын 2.1-д заасны дагуу бүртгүүлж, 14 хоногийн дотор уг зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.~~

~~16. 13.4. Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааны нийлбэр тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд оршин суух зөвшөөрөл авна.~~

~~17. 13.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад оршин суух зөвшөөрөл хүссэн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд татгалзсан, эсхүл түр ирэгчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шалтгааныг тайлбарлах үүрэг хүлээхгүй.~~